



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/160

Чингис хот

Мал амьтны сэг зэм устгал,
орчны халдваргүйтгэлийн ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.3.2, 7.3.3, 7.3.4, 7.3.6 дахь заалтууд, Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвчнөөр болон зүй бусаар үхэж хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг устгаж, халдваргүйтгэх ажлыг 2020 оны 04, 05 дугаар сард багтаан Мал эмнэлгийн байгууллагын заавар, зөвлөмжийн хүрээнд Мал эмнэлгийн тасаг, үйлчилгээний нэгжүүдтэй хамтран орон нутгийн малчид, иргэдийн оролцоотой зохион байгуулсугай.

2. Халдваргүйтгэлийн ажлыг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Удирдлага зохион байгуулалт, мэргэжил арга зүйн заавар зөвлөмж, тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмж, эмийн бодис, халдвар хамгааллын хувцас хэрэгслээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-т, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус хариуцуулсугай.

4. Сэг зэм устгал, халдваргүйтгэлийн ажлын нэгдсэн тайлан, дүн мэдээг нэгтгэн аймгийн Засаг даргын Тамгын газар, холбогдох байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор багтаан танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-т даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА